



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 30 өдөр

Дугаар А/17

Улаанбаатар хот

Орон тооны бус зөвлөлийг шинэчлэн  
байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын 2017 оны 195 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1302 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/788 дугаар тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Албадлагын арга хэмжээ авсантай холбогдуулан хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах асуудлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, шийдвэр гарган, биелэлтэд хяналт тавих үүрэг бүхий Дүүргийн орон тооны бус Зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, зөвлөлийн дэргэдэх үнэлгээ хийх үүрэг бүхий Комиссын бүрэлдэхүүнийг хоёрдугаар, устгалын асуудал хариуцан зохион байгуулах үүрэг бүхий Комиссын бүрэлдэхүүнийг гуравдугаар, худалдан борлуулах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Комиссын бүрэлдэхүүнийг дөрөвдүгээр, дүүргийн Зөвлөлийн ажиллах журмыг тавдугаар, үнэлгээ хийх үүрэг бүхий комиссын дүгнэлтийг зургаадугаар, устгал хийх үүрэг бүхий комиссын актыг долоодугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Зөвлөлийн үйл ажиллагааг журамд заасны дагуу зохион байгуулж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Дүүргийн Засаг даргын 2019 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А/228 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА




А.СҮХБОЛД

АЖИЛ 2024 он ажил захирамж

1123200088

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2024 оны 01... дүгээр сарын 30... ны өдрийн  
8/17... дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



### ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:  
Гишүүд:

- Засаг даргын Тамгын газрын дарга
- Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
- Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
- Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
- Төхижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга
- Дүүргийн Цагдаагийн хэлтсийн дарга
- Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга
- Дүүргийн Татварын хэлтсийн дарга
- Санхүү, төрийн сангийн хэлтсийн Ерөнхий нягтлан бодогч

Нарийн бичгийн  
дарга:

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2024 оны ..... дүгээр сарын ..... ны өдрийн  
A.1.7. дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



### ҮНЭЛГЭЭНИЙ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:  
Гишүүд:

Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга  
Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга  
Дүүргийн Худалдан авах ажиллагааны албаны дарга  
Дүүргийн Статистикийн Ахлах мэргэжилтэн  
Санхүү, төрийн сангийн хэлтсийн  
Хөрөнгө оруулалт, орон нутгийн өмч, сургалт тайлан мэдээ  
хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн  
дарга:

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2024 оны ... дүгээр сарын ... ны өдрийн  
... дугаар захирамжийн гуравдугаар хавсралт



### УСТГАЛЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:  
Гишүүд:

Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга  
Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн  
Худалдаа үйлчилгээ, үйлдвэрлэл хариуцсан ахлах  
мэргэжилтэн  
Эрүүл мэнд, биеийн тамир, индекс хариуцсан  
мэргэжилтэн  
Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн гал түймрийн  
Улсын байцаагч  
Дүүргийн Мал эмнэлгийн хяналтын Улсын байцаагч  
Дүүргийн Цагдаагийн хэлтсийн хэв журмын ажил  
хариуцсан ахлах байцаагч  
Санхүү, төрийн сангийн хэлтсийн  
Хөрөнгө оруулалт, орон нутгийн өмч, сургалт тайлан  
мэдээ хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн  
дарга:

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2024 оны ... дүгээр сарын ... ны өдрийн  
... дугаар захирамжийн дөрөвдүгээр хавсралт



ХУДАЛДАН БОРЛУУЛАХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ  
КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:

Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга

Гишүүд:

Санхүү, төрийн сангийн хэлтсийн  
Банкны төлбөр тооцоо хариуцсан ахлах мэргэжилтэн  
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн  
Эрх зүй, хяналт-шинжилгээ, үнэлгээ, хөрөнгө орлогын  
мэдүүлэг хариуцсан мэргэжилтэн  
Хөрөнгө оруулалт, орон нутгийн өмч, сургалт тайлан  
мэдээ хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн  
Худалдаа үйлчилгээ, үйлдвэрлэл хариуцсан ахлах  
мэргэжилтэн

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2024 оны ... дүгээр сарын ... ны өдрийн  
... дугаар захирамжийн тавдугаар хавсралт



АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭ АВСАНТАЙ ХОЛБООТОЙ ХУРААН АВСАН  
ХӨРӨНГӨ, ОРЛОГО, ЭД ЗҮЙЛ, ХЭРЭГСЛЭЭС ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ,  
УЛСЫН ОРЛОГО БОЛГОХ, УСТГАХ АСУУДЛЫГ ХОЛБОГДОХ ХУУЛЬ  
ТОГТООМЖИЙН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛЖ, ШИЙДВЭР  
ГАРГАН БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ҮҮРЭГ БҮХИЙ  
ДҮҮРГИЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1 Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу албадлагын арга хэмжээ авах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хураан авсан хөрөнгө, орлогоос хохирол нөхөн төлүүлэх, эд зүйл, хэрэгсэл, хөрөнгө, орлогыг улсын орлого болгох, устгахтай холбогдон үүсэх харилцаанд Засгийн газрын 2017 оны 195 дугаар тогтоолоор баталсан “Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгсэлээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах журам” болон энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.2 Зөвлөл нь албадлагын арга хэмжээтэй холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслийг зориулалтаар нь буюу зориулалтыг нь өөрчлөн үнэлэн борлуулж, улсын орлого болгох, хэрэгцээгүй зарим эд зүйлийг устгах талаар зөвлөлдөн шийдвэрлэж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

1.3 Хураасан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслийг Зөвлөлийн шийдвэргүйгээр борлуулах, бусдад шилжүүлэх болон хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчинд шууд хор нөлөө учруулах, түүнчлэн түргэн муудаж чанар байдлаа алддаг, зориулалтыг нь өөрчлөн ашиглах боломжгүй эд зүйлээс бусад эд зүйлийг устгахыг хориглоно.

Хоёр.Зөвлөлийн үйл ажиллагаа

2.1 Зөвлөлийн дарга нь Дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга байх бөгөөд зөвлөлийн үйл ажиллагаанд Дүүргийн Засаг даргын Тамгын газрын тамга тэмдэг, хэвлэмэл хуудсыг хэрэглэнэ.

2.2 Зөвлөл нь эрх бүхий байгууллагаас хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслийг улсын орлого болгох, устгах, бусад байгууллагад шилжүүлэх асуудлыг шийдвэрлүүлэх хүсэлтийг үндэслэн цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан хуралдааныг цахимаар болон танхимаар зохион байгуулна.

2.3 Зөвлөлийн хуралд гишүүдийн гуравны хоёр нь оролцсоноор хүчинтэйд тооцно.

2.4 Зөвлөл нь хэлэлцсэн асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэнэ. Хэрэв санал тэнцвэл Зөвлөлийн даргын саналаар шийднэ.

2.5 Зөвлөлийн хурлаас тэмдэглэл гарах бөгөөд Зөвлөлийн дарга, Нарийн бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

2.6 Зөвлөлийн хуралдааны шийдвэрийн хэрэгжилтэд Зөвлөлийн дарга, Нарийн бичгийн дарга хяналт тавьж ажиллана.

Гурав. Хураагдсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслийг

#### Зөвлөлд танилцуулах

3.1 Хураагдсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслийг тухайн зөрчлийг хянан шийдвэрлэх хүртэл зохих эрх бүхий байгууллага, албан тушаалтны заасан газарт хадгалж, зөрчлийг хянан шийдвэрлэх үед уг эд зүйлийг хураах, эсхүл эзэмшигчид нь буцааж өгөх асуудлыг шийдвэрлэнэ.

3.2 Тухайн зөрчилд хэрэг бүртгэлийн ажиллагаа явуулж, хураан авах ажиллагааг хэрэгжүүлсэн эрх бүхий байгууллага нь Зөвлөлд хураагдсан хөрөнгө, орлого, эд зүйл хэрэгслийг зөвлөлд танилцуулж, шийдвэрлүүлнэ.

3.3 Хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд гэм хор учруулж болзошгүй, түүнчлэн түргэн муудаж, чанар байдлаа алддаг, зориулалтыг нь өөрчлөн ашиглах боломжгүй эд зүйлийг шаардлага хангасан газар, байранд зөрчил гаргасан этгээдийг өөрийг нь болон хоёроос доошгүй хөндлөнгийн гэрч байлцуулан акт үйлдэн, тэмдэглэл хөтлөн, устгалыг баримтжуулж Зөвлөлд танилцуулна.

3.4 Зөвлөл хураагдсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслийг устгасан, улсын орлого болгосон, шилжүүлсэн талаар Зөвлөлөөс зөрчлийн хэрэг бүртгэлийн ажиллагаа явуулсан байгууллагад мэдэгдэн, тухайн байгууллагын эрх бүхий албан тушаалтан холбогдох баримтыг зөрчлийн хэрэгт хавсаргана.

3.5 Зөвлөл эцэслэн шийдвэрлэх хүртэл хугацаанд хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслийн хадгалалт, хамгаалалтыг тухайн зөрчлийн хэрэг бүртгэлт явуулсан эрх бүхий албан тушаалтан, түүнийг харьяалах байгууллага хариуцна.

#### Дөрөв. Үнэлгээ хийх

4.1 Зөвлөлөөс худалдан борлуулах, улсын орлого болгох, устгах, шилжүүлэх шийдвэр гаргахын өмнө тухайн хөрөнгө, эд зүйл, хэрэгсэлд үнэлгээ хийх асуудлыг Үнэлгээний комисс хэрэгжүүлнэ.

4.2 Хөрөнгө, эд зүйл, хэрэгслийн үнэлгээг тухайн үеийн зах зээлийн үнэ, ханшийн жишгийг харгалзан Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд заасан журмын дагуу Үнэлгээний комисс тогтооно.

4.3 Эрх бүхий байгууллагаас хөрөнгө, эд зүйл, хэрэгслийг үнэлсэн бол Үнэлгээний комиссоор дахин үнэлгээ хийлгэх шаардлагатай эсэхийг Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж үнэлэхээр шийдвэрлэсэн бол Үнэлгээний комисст, үнэлэх шаардлагагүй бол Худалдан борлуулах, Устгалын комисст тус тус шилжүүлэх шийдвэрийг гаргана.

4.4 Үнэлгээ хийх явцад тухайн хөрөнгө, эд зүйл, хэрэгслийг үнэлэх боломжгүй гэж үзсэн тохиолдолд энэ тухай Зөвлөлд танилцуулна.

4.4 Үнэлгээний комисс нь хөрөнгө эд зүйлс хэрэгслийн нэр төрөл болон бусад зүйлийг тодорхойлох зорилгоор холбогдох байгууллага, шинжээчээр дүгнэлт гаргуулж болно.

4.5 Үнэлгээний комиссоос тухайн хөрөнгө, эд зүйл, хэрэгсэлд үнэлгээ тогтоох боломжгүй гэж үзсэн тохиолдолд хөндлөнгийн шинжээчээр үнэлгээ хийлгэх ажлыг Үнэлгээний комиссын хурлаар шийдвэрлэж үнэлгээ тогтоох ажлыг зохион байгуулна.

4.6 Хураагдсан амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, эрдэс чулуу, химийн болон цацраг идэвхт бодис, нян, есгөвөр, эм, эмийн түүхий эд, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг шинжилгээнд хамруулсны үндсэн дээр Зөвлөлөөс худалдан борлуулах, шилжүүлэх эсхүл устгах шийдвэр гаргана.

4.7 Үнэлгээний комисс нь худалдан борлогдоогүй хөрөнгө, эд зүйл, хэрэгслийг

дахин буюу хоёр дахь удаа үнэлэхдээ анхны үнэлсэн үнэлгээний үнийн 50 хувиар тооцон тогтооно.

4.8 Үнэлгээний комисс нь худалдан борлогдоогүй хөрөнгө, эд зүйл, хэрэгслийг дахин буюу гурав дахь удаа үнэлэхдээ анхны үнэлсэн үнэлгээний үнийн 80 хувиар тооцон тогтооно.

#### Тав.Бусад зүйл

5.1 Энэхүү журам нь Зөвлөлийн дотоод үйл ажиллагааг зохицуулна.

5.2 Зөвлөлөөс гарах шийдвэрийн биелэлтэд прокурорын байгууллага холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хяналт тавина.



Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2024 оны .../... дүгээр сарын .../... ны өдрийн  
... дугаар захирамжийн зургаадугаар хавсралт



ҮНЭЛГЭЭ ХИЙХ ҮҮРЭГ БҮХИЙ КОМИССЫН ДҮГНЭЛТ

202...оны ... сарын ...-ны өдөр

Дугаар ...

Багахангай дүүрэг


Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 195 дугаар тогтоолоор баталсан “Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах журам”-ыг удирдлага болгон Нийслэлийн Засаг даргын ... оны ... дугаар захирамжаар баталсан албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, шийдвэр гарган биелэлтэд хяналт тавих үүрэг бүхий нийслэлийн Зөвлөлийн бүрэлдэхүүн 202... оны ... сарын ...-ны өдрийн ... дугаар хуралдаанаар

..... шалтгаанаар  
хавсралтад дурдсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслийг

..... үнэлэв.  
(Үнэлгээний хавсралтыг хавсаргав.)

Үнэлгээ хийсэн зөвлөлийн гишүүд:

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2024 оны ..... дүгээр сарын 30 ны өдрийн  
А.П.З. дугаар захирамжийн долоодугаар хавсралт



УСТГАЛЫН АСУУДАЛ ХАРИУЦАН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ҮҮРЭГ БҮХИЙ КОМИССЫН АКТ

202...оны ... сарын ...-ны өдөр

Дугаар ...

Багахангай дүүрэг

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 195 дугаар тогтоолоор баталсан “Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах журам”-ыг удирдлага болгон Нийслэлийн Засаг даргын ... оны ... дугаар захирамжаар баталсан албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, шийдвэр гарган биелэлтэд хяналт тавих үүрэг бүхий нийслэлийн Зөвлөлийн бүрэлдэхүүн 202... оны ... сарын ...-ны өдрийн ..... дугаар хуралдаанаар.....

..... шалтгаанаар хавсралтад дурдсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслийг ..... үнэлэв.  
(Устгалын хавсралтыг хавсаргав.)

Устгал хийсэн зөвлөлийн гишүүд: